

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2020 ОНЫ 12 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 14

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журмын дагуу 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдөр дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрөл, бүртгэлийн чиглэлээр:

Тайлант хугацаанд гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг уригч байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн гадаадын 11 иргэнд визийн зөвшөөрөл, 31 иргэнд виз олгосон байна.

Холбогдох төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн гадаадын 77 иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 162 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 8 иргэнийг бүртгэлээс хасаж, оршин суугаа хэлбэр нь өөрчлөгдсөн 2 иргэнд визийн ангилал солих үйлчилгээ үзүүлжээ.

Уригч 2 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу гадаадын 2 иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгосон.

Монгол Улсад түр ирэгчээр ирсэн гадаадын 1 иргэнийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн гадаадын 7 иргэний бүртгэлд хасалт хийсэн.


Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн, мөн визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан гадаадын 1 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан.

Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 68 шинээр хэвлэж, 70 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 3 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийсэн байна.

Оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, хүсэлт гаргасан гадаадын 57 иргэний хүсэлтийг Газрын даргын 2 удаагийн тушаалаар тус тус шийдвэрлэсэн. Гадаадын 1 иргэнд регистрийн дугаар олгосон.

Гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны

сунгалтын асуудлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад дараах байдлаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



2020 оны 12 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 97 хувиар, виз олголт 97.7 хувиар, хувийн урилга олголт 100 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 72.2 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 81.9 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 99.1 хувиар, түр ирэгчийн бүртгэл 97 хувиар, түр ирэгчийн хасалт 95 хувиар, визийн сунгалт 96.7 хувиар тус тус буурсан байна.

Үйл ажиллагааны үзүүлэлтийн энэ бууралт нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газар болон Улсын онцгой комиссын шийдвэрээр гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж хилийн боомтоор нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбоотой юм.

Үйлчилгээний зааланд давхардсан тоогоор 29 аж ахуйн нэгж, байгууллагын 56 иргэний хүсэлтийг хүлээн авч үйлчилсэн бөгөөд өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэдийн Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн сунгалтыг цахимаар авч эхэлсэн. Тайлант хугацаанд “Т” ангиллын 35 аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын 106 иргэн, “НГ” ангиллын 24 аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын 300 иргэн, нийт давхардсан тоогоор 59 аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын 406 иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн.

Бүх нийтийн бэлэн байдлын үед гадаадын иргэдийн виз, бүртгэл, хасалт, оршин суух зөвшөөрлийн олголт, сунгалтын 47 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг и-мэйлээр хүлээн авсан. Онлайн туслах үйлчилгээг 115 иргэн, аж ахуйн нэгжид үзүүлж ажилласан байна.

Мөн 1800-1882 дугаарын утсаар 388, 7585-1882 утсаар 9, биечлэн 24, автомат хариулагчаар 118, нийт 616 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Код мессеж үйлчилгээ 4 иргэнд илгээж, паспорт 26, оршин суух үнэмлэх 54 гадаадын иргэнд буцаан олгосон.

1.2. Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяатаас гарч Японы 2, Бүгд Найрамдах Австри Улсын харьяат болох хүсэлт гаргасан 1, нийт 3 иргэний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авсан.

Монгол Улсын харьяатаас гарч Бүгд Найрамдах Солонгос Улсын харьяат болох хүсэлт гаргасан 3 иргэний хүсэлтэд санал авахаар Улсын Бүртгэлийн Ерөнхий газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газарт, Монгол Улсын харьяатаас гарч Бүгд Найрамдах Казахстан Улсын харьяат болох хүсэлт гаргасан 13 иргэний хүсэлтийг хянан холбогдох байгууллагуудаас санал авч, Ерөнхий сайдад танилцуулан дүгнэлт үйлдэн Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Иргэний харьяаллын талаарх тодорхойлолт хүссэн 1 иргэнд Монгол Улсын харьяатаас гарсан талаарх тодорхойлолт олголоо. Өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор гадаадын иргэдийн нэгдсэн бүртгэлийн санд 51 улсын 3801 хоёрдмол харьяалалтай иргэд бүртгэлтэй байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад үрчлэгдсэн 1 хүүхдийн тайланг хүлээн авч мэдээллийн санд бүртгэсэн. Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд 272 хүүхэд үрчлэгдээд байна.

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаагаа сунгуулах 1 байгууллагын хүсэлтийг хүлээн авсан. 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар гадаадын 86 төрийн бус байгууллага бүртгэлтэй байна. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд хяналт тавих журмын төслийг боловсруулан ажлын хэсэгт танилцуулахаар бэлдэж байна.

1.3. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 4 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн.

Виз, зөвшөөрөл, харьяатын газраас 19 аж ахуйн нэгж, байгууллагын 9 улсын 15 иргэний хөрөнгө оруулалт нь бодитой эсэхийг шалгуулахаар шилжүүлсэн хүсэлтийг хүлээн авч, 29 аж ахуйн нэгжийн хүсэлтийг шалгаж байна.

Байгууллагын даргын 01-04/10 дугаарын удирдамжийн дагуу Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авахаар АНУ-ын 1 гэр бүлийн гаргасан хүсэлтээр харьяа хорооны нутаг дэвсгэр дэх хаягаар нь хяналт шалгалт хийж, үрчлэгдэх хүүхдийн нөхцөл байдал, асран хамгаалагчаас нь мэдүүлэг авах, үрчлэгдэх шаардлага хангасан эсэхийг шалгалаа.

Байгууллагын даргын 01-04/11 дугаарын удирдамжийн дагуу 4 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газраас зөвшөөрлийн хугацаагаа сунгуулахаар ирүүлсэн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүнг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр танилцуулсан байна. Шалгалтад БНСУ-ын 1 иргэн хамрагдсан бөгөөд зөрчилгүй байлаа.



2020 оны 12 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 91.4 хувиар, уригч хуулийн этгээд 92.2 хувиар, албадан гаргагдсан, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн гадаадын иргэн тус тус 100 хувиар буурсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, баривчлах ял эдлүүлэх байранд энэ оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 10 улсын 19 иргэн ял эдэлж байгаагаас хаалттай хорих ангид 5 улсын 5 иргэн, нээлттэй хорих ангид 7 улсын 14 иргэн байна. Мөн 4 улсын 26 иргэн цагдан хоригдсон мэдээллийг ирүүлжээ.

Цагдаагийн байгууллагад гэмт хэрэгт шалгагдаж буй Австрали улсын 1, БНХАУ-ын 31, ОХУ-ын 1, БНСУ-ын 3, ХБНГУ-ын 1, нийт 5 орны 37 иргэний паспорт хураагдаж ирснийг бүртгэлд хамруулан, хяналт тавин ажиллаж байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

### 2.1. Захиргаа, удирдлагын чиглэлээр:

Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу Үнэлгээний багийг байгууллагын зохион байгуулалтын нэгжийн дарга нарын бүрэлдэхүүнтэй байгуулан байгууллагын даргаар 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/267 дугаараар батлуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайд байгууллагын үйл ажиллагаатай танилцахад өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийг гарган 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/1782 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2021 онд улсын төсвийн санхүүжилтээр зохион байгуулагдах богино, дунд хугацааны зайны болон танхимын сургалтад хамрагдах албан хаагчдын мэдээллийг гаргаж, Удирдлагын академид 2021 оны 12 дугаар сарын 03-ний өдөр цахимаар хүргүүллээ.

Нууцын зэрэглэлтэй ирсэн 2 албан бичгийг холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, нууцын зэрэглэлтэй явсан 1 албан бичгийг биечлэн хүргэсэн.

Виз, зөвшөөрөл харьяатын газрын дарга Д.Алтанзул, Захиргаа, удирдлагын газрын аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн П.Гантулга, Дорноговь аймаг дахь газрын дарга П.Эрдэнэбаатар, Зүүн бүс дэх газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Төрхүү нарт төрийн нууцтай танилцах эрх, аюулгүй байдлын шалгалтад хамрагдах талаар зөвлөж, холбогдох материалыг 2020 оны 12 дугаар 09-ний 01/1811 дугаар албан бичгээр Тагнуулын ерөнхий газарт хүргүүлэн ажиллалаа.

Байгууллагын даргын 2020 оны Б/297 дугаар тушаалаар 1 албан хаагчид тэмдэг түшүүлэх ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын даргын 2020 оны 03 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”, мөн оны 04 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Хилийн авто замын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал ирүүлэх талаар 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 3599 дугаар албан бичгийн хариуг 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1810, мөн өдрийн Улсын онцгой комиссын 3590 дугаартай Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах санал ирүүлэх талаар албан бичгийн хариуг 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/1797 дугаар албан бичгээр Улсын онцгой комиссын ажлын албанд тус тус хүргүүлж ажилласан.

Мөн 12 дугаар сарын 14-ний өдрөөс Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулж өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж буйтай холбогдуулан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан 12 дугаар сарын 09-ний өдрийн 01-03/144 дугаар илтгэх хуудсаар “Гамшгаас хамгаалах шуурхай штаб”-ын даргад танилцуулсан.

Төв болон харьяалах хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд “Ажлын байранд Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх шалгах хуудасны загвар”-ын дагуу ажлын байр тус бүрээр асуумжийг боловсруулан, дүгнэх баг томилон хэрэгжүүлж ажиллах талаар “Гамшгаас хамгаалах шуурхай штаб”-ын даргын 12 дугаар сарын 10-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 11 дүгээр албан даалгаврыг боловсруулан батлуулж, хүргүүлж ажилласан.

Ажлын зайлшгүй шаардлагаар 2020 оны ээлжийн амралтаа биеэр эдлээгүй нэр бүхий 7 албан хаагчид 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох тушаалын төслийг боловсруулж батлуулсан. Мөн тайлант хугацаанд төрийн захиргааны түр 1, төрийн үйлчилгээний түр 1, нэгж хооронд 2 албан хаагчийг шилжүүлэн ажилласан.

Байгууллагын даргын албан тушаалын сонгон шалгаруулалт 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд нээлттэй зарлагдсантай холбогдуулан агентлагийн даргын танилцуулга, хүсэлт, асуумж, төрийн алба хаасан хугацааны мэдээлэл болон холбогдох бусад материалыг бэлтгэн, 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр эхлэх цахим бүртгэлд оруулах бэлтгэлийг ханган ажиллаа.

Байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн 2 гишүүнийг нөхөн сонгох зорилгоор 222 албан хаагч хамруулан санал асуулга зохион байгуулж, олонхын санал авсан 2 албан хаагчийг байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 03-ны Б/356 дугаар тушаалаар ёс зүйн зөвлөлийн гишүүнээр томилсон.

Мөн төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын сул орон тооны судалгаа, төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа тусгай шалгалт өгөх албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж байгууллагын удирдлагад танилцууллаа.

Засгийн газрын “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 2020 оны 194 дүгээр тогтоол, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар баталсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам”, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242 дугаар захирамжийн дагуу Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл сунгасантай холбогдуулан гэрээсээ цахимаар ажиллах болон ажлын байранд ажиллах албан хаагчдын хуваарь, жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй эхчүүд /ганц бие эцэг/-ийн нэрс, хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажиллах албан хаагчдын нэрсийг агентлагийн даргын А/265 дугаар тушаалаар батлуулан, зохион байгуулалтын нэгжийн дарга нарт цахим шуудангаар хүргүүлэв.

Эрсдэлийн үнэлгээний тайлантай холбогдуулан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийсэн 2020 оны ажлын тайланг Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүлээлгэн өгсөн.

Тайлант хугацаанд албан хаагчаас ажлаас чөлөөлөгдөх 1, ээлжийн амралт эдлээгүй урамшуулал хүссэн 1, хилийн боомтод ажилласан хугацааны нэмэгдэл хүссэн 1, иргэнээс ажилд орох хүсэлт 1, нийт 4 өргөдөл ирсний 3 өргөдлийг шийдвэрлэж, шинээр томилогдох хүсэлт гаргасан 1 өргөдөл ажиллагаанд байна. Тайлант хугацаанд хүний нөөцтэй холбоотой “А” тушаал 2, “Б” тушаал 5, захиргааны шийдвэрийн хувийн хэрэгт 59 хуудас бүхий хяналтын дагалдах хуудсыг бүрдүүлж ажиллаа.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 6 мэдээ, мэдээллийг цахим сайтад байршуулж, олон нийтэд мэдээллээ. Тухайлбал, “ГИХГ цахимаар үйлчилгээ үзүүлж байна” мэдээ монгол хэлээр montsame.mn, mnb.mn, 24tsag.mn, updown.mn, ontslokh.mn сайтад, англи хэлээр news.mn, montsame.mn зэрэг 13 сайтад, “ГИХГ бүртгэлийн цэг уншуулах QR код байршууллаа” мэдээг zindaa.mn, mnb.mn, 24barimt.mn сайтуудад тус тус нийтлүүлэн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ авахтай холбоотой мэдээ мэдээллийг тогтмол байршуулж байна.

Байгууллагын үйл ажиллагаа, үндсэн чиг үүрэг, албан хаагчидтай холбогдох мэдээлэлд тухай бүр хяналт тавьж, өдөр тутам “ГИХГ”, “Гадаадын иргэн, харьяатын газар”, “гадаадын иргэн, харьяат”, “гадаадын иргэн”, “Монголын иммигрэйшн” гэх мэт түлхүүр үгнүүдийг ашиглан мониторинг хийж ажиллав. Тайлант хугацаанд “ГИХГ-ын ажилтныг хахуульдахыг завдсан өвөрлөгч эр Балжиннямыг саатуулжээ”

мэдээ asu.mn, livetv.mn, tac.mn, moogle.mn сайтад нийтлэгдсэн. Тус мэдээллийг цахим сүлжээн дэх 28 группд түгээж, мэдээллийн сайтад нийтлэгдсэн мэдээллийг архивласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 6 мэдээлэл, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх зөвлөмж, зөвлөгөө бүхий 8 зурагт хуудас, албан хаагчдад зориулсан 3 зурагт хуудас мэдээлэл байршуулж ажиллалаа.

Өнөөдрийн байдлаар байгууллагын цахим хуудас 13737 дагагчтай, хандалт дунджаар 8400 орчим байна.

Холбогдох зөвшөөрлийн дагуу 5 ажилтан, алба хаагчид 26 хадгаламжийн нэгжийг ашиглалтад олгож, тухай бүр бүртгэл хөтөлж, ашиглалтын хуудас хөтөлж, 85 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулсан.

Монгол Улсын иргэний харьяалалтай холбогдох 8 хадгаламжийн нэгжийг PDF-д хөрвүүлсэн цахим баримтаас 2 хадгаламжийн нэгжийн 489 хуудас баримтыг байгууллагын цахим архив программд холбов.

Байгууллагад ирсэн нийт 59 албан бичгийг удирдлагад танилцуулан бүртгэсэн. Үүнээс хариутай 28 албан бичиг, хариугүй 31 албан бичгийг холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн. Эдгээрээс шийдвэрлэгдсэн 13 албан бичиг, шийдвэрлэх шатандаа байгаа 15 албан бичиг байна. Мөн дотоодод ирсэн 1 албан бичгийг бүртгэлийн дэвтэрт бүртгэн холбогдох алба хаагчдад хүлээлгэн өгч, 53 албан бичгийг албан хаагчдаас хүлээн авч, бүрдлийг шалгаж, 31 албан бичгийг шуудангаар явуулсан.

Тайлант хугацаанд А тушаал 5, Б тушаал 8, дэд даргаас албан даалгавар 1 гарсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд 6 өргөдөл ирж, шийдвэрлэлтийн шатанд байна. Хуулийн хугацааг сунгасан болон хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй. Өргөдөл гомдлын агуулга: Дотооддоо урамшуулал хүссэн 2, ажлаас чөлөөлөгдөх 1, иргэд байгууллагаас оршин суух болон визийн зөвшөөрөл олгох, сунгаж өгөхийг хүссэн 2, албадан гаргахаас чөлөөлүүлэх тухай 1 хүсэлт байлаа.

Байгууллагын 15 албан хаагчид анхан шатны үзлэг оношилгоо хийж, 4 эмийн жор бичиж, нийт 7 албан хаагчид зөвлөгөө өгч, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх халдвараас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих зорилгоор нийт албан хаагчдад 300 гаруй витамин витаминыг тараалаа.

## 2.2. Эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж гарах эрх зүйн актыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа тогтоох журам”, “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болох түүнийг бүртгэх журам”-ын төслийн эхний хувилбарыг боловсруулав.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хугацааг сунгахтай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Улсын онцгой комисст 2020 оны 12 дугаар сарын 02-ны 01/1775 дугаар албан бичгээр хүргүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд А тушаалын төсөл 1, Б тушаалын төсөл 4, Агаарын замын боомт хариуцсан газраас ирүүлсэн “Автомашинны граж түрээслэх гэрээ”-ний төсөл хянав.

Нийтийн албанд шилжин томилогдох 1 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэлийг системд үүсгэж, мэдүүлэгт хяналт тавьж холбогдох албан бичгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн, шинээр томилогдсон 18 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан баталгаажуулж ажиллаа.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн хэрэгжилтийн судалгааг гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2020 оны 12 дугаар сарын 07-ны 01/1799 дугаар албан бичгээр хүргүүлэв.

БНХАУ, ХБНГУ, ОХУ, Япон, БНЭУ, БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-дад тус байгууллагын зарим үйлчилгээг цахимаар үйлчлэх болсон талаар мэдэгдэв.

Тайландын олон улсын хамтын ажиллагааны агентлагаас 2020 оны 12 дугаар сарын 07-ноос 18-ны өдрүүдэд зохион байгуулж буй “Хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөний сайн туршлагаас суралцаж бололцоот ажлыг дэмжих нь” сэдэвт цахим семинарт хуулийн ахлах мэргэжилтэн М.Уранбилэг хамрагдаж байна.

### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

eVisa системийн нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд хүсэлт хүлээн авч тусгай тэмдэглэл хийх нэмэлт хөгжүүлэлтийг хийж 9-ний өдөр, мөн CAO програм хангамжид хэрэглэгчийн шаардлагын дагуу тайлан хэсгийг шинээр хийж 10-ны өдөр тус тус ажиллагаанд оруулсан.

Шинээр тоон гарын үсэг ашиглах 10 албан хаагчид холбогдох зөвшөөрлийг Үндэсний дата төв УТҮГ-аас 12 дугаар сарын 3-ны өдөр авч гарын авлагын хамт албан хаагчдад тарааж, шинээр томилогдсон, нууц үгээ мартсан, мэйл хаягийн багтаамжийн хэмжээ дүүрсэн зэрэг 24 албан хаагчийн хүсэлт, дуудлагын дагуу мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллаа.

Эх бэлтгэл, хэвлэлийн ажлын хүрээнд А4 хэвлэл 450ш, А3 хэвлэл 270ш, А5 200ш, утасны ном 50ш, зурагт хуудсын эх 20ш, 2021 оны календарийн загвар 4ш тус тус бэлтгэсэн.

### 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын /төсвийн төвлөрүүлэн захирагч/ багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2020 онд 7729.8 сая төгрөг батлагдсанаас Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар тодотгон бараа үйлчилгээний зардлаас 390.3 сая төгрөг хасагдаж 7339.5 төгрөгийн төсөв батлагдсан.



Энэ оны 12 дугаар сарын 15-ны байдлаар өссөн дүнгээр 7,388.9 сая төгрөгийн зарцуулах эрх тавигдсанаас 5,759.7 сая төгрөг буюу 77%-ийн зардлын гүйцэтгэл гарч батлагдсан төсвийг зориулалтын дагуу зохих дүрэм, журамд нийцүүлэн анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэлийн 2020 оны 11 дүгээр сарын мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2020 оны 12 сарын 02-ны өдөр хуулийн хугацаанд хүргүүлсэн.

УИХ-аас 2020 оны төсвийн тодотголыг баталсантай холбогдуулан хэмнэгдэж байгаа зардлаас дутагдалтай байгаа зардлуудад гүйлгэн зарцуулах тооцооллыг хийж 12 дугаар сарын төсвийн хуваарьд өөрчлөлт оруулах саналыг бүх харьяа газруудаас авч саналаа нэгтгэн боловсруулж, дэлгэрэнгүй тайлбарын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд мэйлээр хүргүүлэн санхүүжилтийг бүрэн хүлээн авсан.

2020 оны худалдан авах ажиллагааны тайланг 2021 оны 11 дүгээр сарын 24-ний 01/1755 тоот албан бичгээр, 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 01-ний 01/1769 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагын цахим хуудсанд төсвийн гүйцэтгэл хэсэгт оруулах мэдээлэл 20, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт хэсэгт оруулах мэдээлэл 20, бусад хэсэгт оруулах мэдээлэл 36 тус тус мэдээлж, “Б” байрны 3 давхарт байрлах шилэн дансны самбарт байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, төсвийн хэлбэлзэл, төсвийн хуулга, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчилж байршуулсан. Харьяа төсөвт нэгжүүдэд шилэн дансанд мэдээллээ цаг хугацаанд нь оруулж байх талаар зөвлөмж өгч ажиллаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоол, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2020 оны 12 дугаар сарын 14-ний байдлаар тэмдэгтийн хураамжийн орлого өссөн дүнгээр 1152.3 сая төгрөг, хүү торгуулийн орлого 77.3 сая төгрөг, Орон нутгийн бүсүүдийн орлого өссөн дүнгээр тэмдэгтийн хураамжийн орлого 686.6 сая төгрөг, хүү торгуулийн орлого 341,5 сая төгрөг, нийт 1838.9 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлж, холбогдох нэгжүүдтэй тооцоо нийлсэн.

Гадаадын иргэн харьяатын газрын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар 2021 онд 7,386.64 сая төгрөг батлагдсан ба 2021 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг 2020 оны 12 дугаар сарын 15-ны 01/1837 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 02-ны Хөрөнгийн тооллого явуулах тухай А/266 дугаар тушаалыг гаргуулан орон нутагт хүргүүлж, тооллогын комисс байгуулж ажиллахыг үүрэг болгож, “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах, ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох, зөвшөөрөл олгох тухай” Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 377 дугаар тогтоол, “Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай” Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны А-1/1664 дүгээр албан бичгийн хэрэгжилтийг тус тус гаргаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 06/1809 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор шүршдэг гар ариутгагч бодис, шүршдэг өрөө тасалгаа цэвэрлэгч, нэг удаагийн бээлий, хамгаалалтын хэрэгсэл болон нэг удаагийн маск, шатахуун талон, үнэт цаас олгож, байгууллагын ажилчдыг өдөр бүр аарц, дархлаа дэмжих чацаргана, бусад хангамжийн материал олгож холбогдох тооцооллыг хийсэн.

#### 2.5. Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн чиглэлээр:

Тус байгууллагын 2020 оны 11 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/1788, 01/1789, 01/1790 дугаартай албан бичгээр Монгол Улсын ерөнхий сайдын ахлах зөвлөх, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд тус тус хүргүүлсэн.

Дотоод аудитын чиглэлээр 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/1795, Төрийн аудитын газрын зөвлөмжийн биелэлтийг 01/1794, Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 2020 оны 11 дүгээр сарын статистик тайлан мэдээг энэ оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/1786 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Байгууллагын 2020 оны 12 дугаар сарын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон 11 дүгээр сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 2020 оны 12 дугаар сарын 04, 07-ны өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэв.

Төв болон орон нутаг дахь нэгжүүдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2020 оны 11 дүгээр сарын байдлаар хяналт тавьж, хяналт, шалгалтын үр дүнг нэгжийн даргад 09/69 дүгээр илтгэх хуудсаар танилцуулж, Зүүн бүс дэх газарт хийсэн дотоод аудитын хүрээнд 01-09/05 дугаар зөвлөмж боловсруулан байгууллагын удирдлагад танилцуулан ажилласан.

Төв болон орон нутаг дахь нэгжүүдэд эрсдэлийн үнэлгээний санал ирүүлэх тухай дотоод албан бичиг хүргүүлэн, холбогдох газруудаас ирүүлсэн санал, тус байгууллагын 2020 оны үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд тулгуурлан эрсдэлийг тодорхойлж, 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 01-09/70 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулахаар гаргаж ажилласан болно.

Хөлөг ажилтан, олон улсын тээвэр гүйцэтгэж байгаа гадаадын иргэн болон тусгай үүргийн нислэгээр ирсэн гадаадын иргэдэд хяналт тавьж ажиллах хүрээнд 11 орны 255 гадаадын иргэн Монгол Улсын хилээр орж, 10 орны 278 гадаадын иргэн хилээр гарсан. Нийт 12 орны 533 гадаадын иргэний хил нэвтрэлтэд хяналт тавихад ямар нэгэн зөрчилгүй байсан болно.

Өмнөд бүс дэх газрыг албаны байртай болгох, албан хаагчдыг ая тухтай ажиллах нөхцөлөөр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх зорилгоор баригдаж байгаа барилгын ажил коронавирусын /ковид-19/ нөхцөл байдлын улмаас үргэлжлэн хийгдэлгүй зогссон болно.

ДАРГА

Н.УУГАНБАЯР

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА

Д.МӨНХБААТАР

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Д.ДАВААНЯМ

НЭГТГЭСЭН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.ЭРДЭНЭБАТ